2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	199,956,400.00	192,605,959.22	192,605,959.22
210201	Тэтгэврийн даатгал	144,571,200.00	137,833,380.34	137,833,380.34
210202	Тэтгэмжийн даатгал	13,846,300.00	13,437,388.61	13,437,388.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,077,000.00	10,750,070.65	10,750,070.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,769,300.00	3,115,086.62	3,115,086.62
210205	Эрүүл мэндийн даатгал	27,692,600.00	27,470,033.00	27,470,033.00
2103	<b>Байр ашиглалттай холбостой тогтмол зардал</b>	334,610,300.00	314,155,956.00	314,155,956.00
210301	Гэрэл, цахилгаан	18,399,100.00	16,301,234.00	16,301,234.00
210302	Түлш, халаалт	308,535,400.00	289,207,502.00	289,207,502.00
210303	Цэвэр, бохир ус	7,675,800.00	8,647,220.00	8,647,220.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	74,832,200.00	74,832,191.00	74,832,191.00
210401	Бичиг хэрэг	5,532,300.00	5,686,848.00	5,686,848.00
210402	Тээвэр, шатахуун	38,622,000.00	38,908,991.00	38,908,991.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,485,900.00	5,548,850.00	5,548,850.00
210404	Ном, хэвлэл	1,592,500.00	1,735,400.00	1,735,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,006,900.00	8,981,852.00	8,981,852.00

**Тарагт сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,592,600.00	13,970,250.00	13,970,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>82,554,500.00</b>	<b>81,807,680.00</b>	<b>81,807,680.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,452,000.00	21,452,000.00	21,452,000.00
210502	Хоол, хүнс	52,834,100.00	52,688,380.00	52,688,380.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,268,400.00	7,667,300.00	7,667,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,699,600.00</b>	<b>29,043,000.00</b>	<b>29,043,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,922,800.00	10,922,800.00	10,922,800.00
210602	Тавилга	10,080,000.00	1,430,000.00	1,430,000.00
210604	Урсгал засвар	16,696,800.00	16,690,200.00	16,690,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,166,800.00</b>	<b>6,110,900.00</b>	<b>6,110,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,166,800.00	6,110,900.00	6,110,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,110,000.00</b>	<b>6,103,559.00</b>	<b>6,103,559.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,888,700.00	2,888,700.00	2,888,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,978,600.00	1,332,000.00	1,332,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	699,400.00	699,000.00	699,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	454,500.00	256,800.00	256,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,100.00	52,000.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	720,000.00	720,000.00
210807	Газрын төлбөр	287,700.00	155,059.00	155,059.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>303,331,800.00</b>	<b>108,316,103.00</b>	<b>108,316,103.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	296,522,300.00	101,506,603.00	101,506,603.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,809,500.00	6,809,500.00	6,809,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,645,600.00</b>	<b>25,640,800.00</b>	<b>25,640,800.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,645,600.00</b>	<b>25,640,800.00</b>	<b>25,640,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,260,000.00	22,260,000.00	22,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,385,600.00	3,380,800.00	3,380,800.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>173,526,900.00</b>	<b>126,157,500.00</b>	<b>126,157,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>173,526,900.00</b>	<b>126,157,500.00</b>	<b>126,157,500.00</b>
223001	Бусад хөрөнгө	173,526,900.00	126,157,500.00	126,157,500.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>125,225,000.00</b>	<b>94,041,400.00</b>	<b>-</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	125,225,000.00	94,041,400.00	94,041,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,838,213,500.00</b>	<b>2,465,219,950.25</b>	<b>2,461,320,961.25</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,341,923,700.00</b>	<b>1,341,923,700.00</b>	<b>2,185,799,270.25</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,341,923,700.00	1,341,923,700.00	1,341,923,700.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,045,168,300.00</b>	<b>972,925,370.25</b>	<b>129,049,800.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	916,118,500.00	843,875,570.25	-

Тарагт сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	129,049,800.00	129,049,800.00	129,049,800.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>34,107,000.00</b>	<b>33,930,280.00</b>	<b>33,930,280.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,107,000.00	33,930,280.00	33,930,280.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>417,014,500.00</b>	<b>116,440,600.00</b>	<b>112,541,611.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,825,000.00	67,507,350.00	67,507,350.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	209,770,000.00	48,933,250.00	48,933,250.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>114,191,634.00</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>96,963,384.00</b>	<b>-</b>

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Данс	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>201,520,105.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>201,520,105.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>170,360,105.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,865,903.00</b>
210101	Үндсэн цалин	2,865,903.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>374,097.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	374,097.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,184,938.00</b>
210401	Бичиг хэрэг	118,186.00
210402	Тээвэр, шатахуун	1,147,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,884,752.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>113,538,392.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,538,392.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,616,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,616,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,779,875.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,779,875.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,160,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,800,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,800,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>360,000.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	360,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>201,520,105.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>201,520,105.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,467,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,052,705.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тарагт сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.14-нөөс 2022.03.20-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.13-ны өдрийн 63 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 7 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс нийт 11 тайлан нэгтгэгджээ.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.“Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно.” гэж заасан.

Мөн хуулийн 36.1.“Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тарагт сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тарагт сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3 тэрбум 906.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 39.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 27.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 28.2 сая төгрөгөөр өссөн байна.

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	200.9	229.1	28.2
31211	Төрийн сангийн харилцах	200.9	229.1	28.2

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сая төгрөг

Орон нутгийн хөгжлийн сан	2.9
Эрсдлээс хамгаалах сан	6.4
Орон нутгийн ерөнхий орлого	45.5

### 3.5.2 Авлага

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Эзлэх хувь
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>261.4</b>	<b>382.7</b>	<b>121.3</b>	100.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.4	4.8	4.4	1.3
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5.7	36.0	30.3	9.4
33400	Зээлийн хүүгийн авлага	8.1	9.1	1.0	2.4
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.0	2.9	2.9	0.8
33510	Байгууллагаас авах авлага	17.8	87.8	70.0	22.9
33520	Хувь хүмүүсээс авах авлага	229.4	242.1	12.7	63.3

Хувь хүмүүсээс авах авлагын 222.6 сая төгрөг нь СХСангаас олгосон зээлийн авлага, 18.3 сая төгрөг нь эрсдэлээс хамгаалах сангаас малчдад олгосон өвс тэжээлийн авлага байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 35.7 сая төгрөгөөр өссөн байна.

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Эзлэх хувь
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>179.1</b>	<b>214.8</b>	<b>35.7</b>	100.0
35110	Тусгай зориулалтын материал	9.4	11.2	1.8	5.2
35130	Эм боох материал	9.8	15.7	5.9	7.3
35400	Хангамжийн материал	159.9	187.9	28.0	87.5
35600	Мал амьтад	0.3		-0.3	

Тайлант онд бараа материалын үлдэгдэл ЭМТөвд 16.8 сая төгрөгөөр өссөн нь ковидын эмчилгээ үйлчилгээтэй холбоотой эм боох материал, тусгай зориулалттай материалын үлдэгдэл эрс нэмэгдсэн байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 290.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Код	Үзүүлэлт	Хөрөнгийн дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	6,187.5
2	Нэмэгдсэн	340.5
201	Худалдан авсан	13.8
203	Шилжүүлэн авсан	
205	Бусад	326.6
3	Хасагдсан	49.8
301	Худалдсан	16.3
303	Шилжүүлсэн	33.5
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	6,478.2

Тарагт сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 340.5 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 13.8 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 326.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 16.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж, 33.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

### 3.5.5 Өр төлбөр

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Эзлэх хувь
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>8.5</b>	<b>61.4</b>	52.9	100
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>8.5</b>	<b>61.4</b>	52.9	100
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	34.4	34.4	56.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	0.0	0.0	0.0
41361	Байгууллагад төлөх өглөг	8.5	27.0	18.5	44.0

Тайлант онд өр төлбөр 52.9 сая төгрөгөөр өссөн нь ЭМТөв ажилчдын цалинд 34.4 сая төгрөгийн өртэй, байгууллагад 1.6 сая төгрөгийн эм болон бараа материалын өртэй гарсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

#### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 02/03 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 63.8 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 83.4 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 19.6 сая төгрөг буюу 30.8 хувиар давж биелсэн байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	26,090,000.00	15,593,764.00	10,496,236.00	59.77
2	Хөрөнгийн орлого	6,912,000.00	10,376,966.99	-3,464,966.99	150.13
3	<b>Хөрөнгө борлуулсны орлого</b>	<b>200,000.00</b>	<b>3,080,000.00</b>	<b>-2,880,000.00</b>	<b>1540.0</b>
4	Бууны албан татвар	1,020,000.00	1,050,000.00	0	102.9
5	<b>Малд ногдуулах албан татвар</b>	<b>0</b>	<b>100.00</b>	<b>-100.00</b>	<b>0</b>
6	Улсын тэмдэгтийн хураамж	1,550,000.00	2,316,850.00	-2,266,950.00	149.5
7	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	13,000,000.00	18,000,000.00	-107,500.00	138.46
8	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,000,000.00	4,149,825.00	425,942.00	138.33
9	Газрын төлбөр	5,033,200.00	8,843,451.00	431,993.00	175.7
	<b>Татварын орлого</b>	<b>56,805,200.00</b>	<b>63,410,956.99</b>	<b>-6,605,756.99</b>	
1	Торгуулийн орлого	7,000,000.00	19,687,500.00	-12,687,500.00	281.25
2	Бусад орлого	0	360,000.00	-360,000.00	
0	<b>Нийт дүн орлого</b>	<b>63,805,200.00</b>	<b>83,458,456.99</b>	<b>-19,653,256.99</b>	<b>130.8</b>

#### 3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2 тэрбум 838.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1 тэрбум 341.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 1 тэрбум 45.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 34.1 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 417 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1 тэрбум 341.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 972.9 сая төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 33.9 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 116.4 сая төгрөг, нийт 2 тэрбум 465.2 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 2 тэрбум 236.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 126.1 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 94 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 25.6 сая төгрөгийг зарцуулжээ.

### **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 201.5 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 170.3 сая төгрөг, тэтгэмж урамшуулалд 30.8 сая төгрөг зарцуулж 0.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тарагт сумын Төрийн сан нь 2021 онд 158 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 157 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар зөрчил илрээгүй байна.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Тарагт сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж байх 1 зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч ажиллалаа.

### 4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 9 байгууллагын 4 байгууллагад дүгнэлт гаргаж, /Тарагт сумын ЗДТГ, цэцэрлэг, СХТөв, ИТХ/ 5 байгууллагыг түүвэрт хамруулсан./Туяа багийн сургууль, ЭМТөв, ЕБ-ийн сургууль, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 88.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 34.4 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 54.5 сая төгрөгийн зөрчилд 29.4 сая төгрөгийн 8 албан шаардлага, 2.2 сая төгрөгийн 2 акт, 22.9 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн.

-ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж сумын ЗДТГазар шинээр 420.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан.

- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой **58.3 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.**

ЗДТГ- Шатахууны 106.3 мянган төгрөгийн жолоочийн тооцоог хийгээгүй

-НДШ-ийн тайлангийн өглөгийг тайланд тусгаагүй

Соёлын төв-Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ хийгээгүй худалдан авалт хийгдсэн.

ИТХ- Нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг дутуу тайлагнасан.

-Шатахууны тайлангийн анхан шатны баримт дутуу

-Шинээр ирсэн автомашины тайлант оны элэгдлийг бодуулаагүй

-Шинээр худалдан авсан 120.0 мянган төгрөгийн дуу хураагчийг зарлагдсан

-Нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг дутуу тайлагнаснаас өглөг үүссэн.

Туяа багийн ЕБС-Түлш халаалтын зардлаас гарсан 6,624.0 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, зарцуулалт анхан шатны баримтаар бүрэн баталгаажгаагүй байна.

-Хоолны захиалгын хуудсаар гарсан зарцуулалтаар дотуур байрны хүүхдийн хоол 411.5 мянга; үдийн хоол 353.5 мянга нийт 765.05 мянган төгрөгөөр эд хариуцагчийн тайлангаас илүү тайлагнасан. Сумын онцгой комисст өгсөн 2,486.9 төгрөгийн хүнсний зарцуулалтыг шаардах хуудсаар хөтлөөгүй, анхан шатны баримтаар бүрэн баталгаажгаагүй байна.

-Дотуур байрны хүүхдийн хоолонд зарцуулсан 10,083.5 мянган төгрөгийг нийт хүүхдийн тоонд харьцуулж үзэхэд дунджаар 2786 төгрөгөөр тооцож олгосон байгаа нь баталсан

нормын хэмжээнд хүрэхгүй байна. Мөн үдийн хоолны нормыг баримталж ажиллаагүй байна.

-ХХОАТ-ын илүү төлөлтийг авлаа дутуу тусгасан.

ЕБС-Хүүхдийн хоолны зардлаас 10.9 сая, үдийн цайны зардлаас 7.0 сая нийт 17.9 сая төгрөгийн хүнсний бараа материал нөөцөлсөн байна.

-Хүүхдийн хоолны зардлаас 0.5 сая төгрөгийг үдийн цайны зардалд шилжүүлэн зарцуулсан байна.

-Бараа материалын тайланд хүүхдийн хоолны зардал, үдийн цайны зардлыг нэгтгэж тайлагнасан байна.

ЭМТөв-Ажилтнуудад цалингийн урьдчилгаа олгохдоо авлагын дансанд бус, цалингийн өглөг дансанд бүртгэсэн байна.

-Газар эзэмших эрх ашиглах хугацааг 0 жилээр тооцож санхүүгийн программд тусгасан.

-Нягтлан бодогч Г.Даваадолгорт ажлын байрны тодорхойлолтод заасан санхүүгийн тайлан гаргах ажилд хамрах хугацаанд 214.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлс бодож олгосон байна.

- Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил

ЗДТГ- Шилэн дансны сайтад 7723.3 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай 7 тушаал шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш 20532.2 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тарагт сумын Төрийн сан	1	0	0	00	0	0	0	0	1	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Р.ЦЭРЭНДОЛГОР

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР